



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 06 сарын 06 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн үндсийг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж

2.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил

3.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн.

3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бодлого боловсруулах, төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх замаар зохион байгуулна.

4 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зорилго

4.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зорилго нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, төр, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, иргэний ухамсар, соёлыг төлөвшүүлэхэд оршино.

5 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн зарчим

5.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дараах зарчмыг баримтална:

5.1.1. хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

5.1.2. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил цогц, тогтвортой, уялдаа холбоотой байх;

5.1.3. төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх;

5.1.4. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээ судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан, техник, технологийн орчин үеийн ололт, амжилт, шинэ мэдлэгт үндэслэсэн байх;

5.1.5. зардал, үр өгөөжийн хувьд үндэслэлтэй байх;

5.1.6. олон нийтийн оролцоонд түшиглэсэн, хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн байх;

5.1.7. төрийн байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хуульд заасны дагуу оролцох үүрэгтэй бөгөөд төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

6 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл

6.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дараах үндсэн чиглэлээр зохион байгуулж, хэрэгжүүлнэ:

- 6.1.1. ерөнхий;
- 6.1.2. тусгай;
- 6.1.3. нэг бүрчилсэн;
- 6.1.4. соён гэгээрүүлэх;
- 6.1.5. гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх.

7 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэх

7.1. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалт, хүмүүжлийн шинж чанартай нийтлэг арга хэмжээг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэл гэнэ.

7.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- 7.2.1. гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах эдийн засаг, нийгэм, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх;
- 7.2.2. иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эдийн засаг, нийгмийн баталгааг бүрдүүлэх;
- 7.2.3. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох;
- 7.2.4. хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлэх;
- 7.2.5. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай санхүү, материал, техникийн болон хүний нөөцийг бүрдүүлэх;
- 7.2.6. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, эрх зүйн бүх нийтийн боловсролыг дэмжих;
- 7.2.7. хүүхдэд хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль дээдлэх ёс, эрх зүйн боловсрол, соёлыг төлөвшүүлэх талаар гэр бүл, нийгэм, сургуулийн орчныг хамарсан цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 7.2.8. хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлэх;
- 7.2.9. хот, тосгоны төлөвлөлтийн үйл ажиллагаанд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл, нийтлэг шаардлагыг хангах;
- 7.2.10. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр суурилуулж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгсэл нь цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох боломжтой байх.

8 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийг хэрэгжүүлэх

8.1. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн цогц арга хэмжээг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тусгай чиглэл гэнэ.

8.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд энэ хуулийн 7.2-т зааснаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- 8.2.1. зохион байгуулалттай гэмт бүлгийн үйл ажиллагааг таслан зогсоох, тэдгээрийн хоорондын харилцаа холбоо, гэмт хэргийн улмаас олсон ашиг орлого, хөрөнгө мөнгөний урсгалыг таслан зогсоох;
- 8.2.2. зохион байгуулалттай гэмт бүлгийн үүсгэн байгуулагч, удирдагчид нэн тэргүүнд хуульд заасан хариуцлага хүлээлгэх зарчмыг хэрэгжүүлэх;
- 8.2.3. зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэхдээ тэдгээрийн гүйцэтгэсэн үүрэг, оролцооноос хамааран ялгамжтай авч үзэх, тэдгээрийн зүгээс хууль сахиулах байгууллагатай сайн дураараа хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- 8.2.4. гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн хууль сахиулах байгууллагатай хамтран ажилласан этгээдийн аюулгүй байдлыг хангах;
- 8.2.5. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг арилгах, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;
- 8.2.6. төсвийн хөрөнгийг зарцуулах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;
- 8.2.7. тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, эсхүл үйлдэгдэж болзошгүй газар нутаг, үйл ажиллагаа, харилцаанд чиглэсэн цогц арга хэмжээг авах;
- 8.2.8. гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг болон үйлдэгдэж болзошгүй газар нутагт урьдчилан сэргийлэх эргүүлийн үйл ажиллагааг тогтмол хийх;
- 8.2.9. гэмт халдлагад өртөж болзошгүй объектыг хамгаалалтад авах, үйл ажиллагааг нь түр зогсоох, тухайн объектоос хүн, эд зүйлсийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх.

8.2.10.Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах.

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.3.Энэ хуулийн 8.2.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэрийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга гаргана.

9 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийг хэрэгжүүлэх

9.1.Тодорхой этгээд гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор түүний зан үйл, ёс суртахуунд нөлөөлөх, түүнээс гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн цогц арга хэмжээг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэл гэнэ.

9.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.2.1.гэмт хэрэг үйлдэж болзошгүй, үйлдэхээр бэлтгэж байгаа этгээдийг цаг тухайд нь олж тогтоох, гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө таслан зогсоох;

9.2.2.гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж суллагдсан хүнд хяналт тавих;

9.2.3.гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа болон хорих ял шийтгүүлж, суллагдсан этгээдэд нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх;

9.2.4.хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тодорхой үүрэг хүлээлгэсэн, хориглолт, хязгаарлалт тогтоосон хүнд хяналт тавих;

9.2.5.гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн зан байдалд нөлөөлөх, хуулийг чандлан сахиж дадал төлөвшүүлэх, хорих байгууллагад байх хугацаанд боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх дадал, туршлага олгох, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох;

9.2.6.энэ хуулийн 12.1.5, 12.1.6-д заасан хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт, шалгалт хийх, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх;

9.2.7.хуульд заасны дагуу гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн гэрч, хохирогч, шаардлагатай тохиолдолд түүний хамаарал бүхий этгээдийг гэмт халдлагаас хамгаалах.

10 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх

10.1.Хүн, хуулийн этгээдийг гэмт халдлагаас хамгаалах, түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирох эрсдэлийг бууруулахад чиглэсэн нөлөөллийн цогц арга хэмжээг соён гэгээрүүлэх чиглэл гэнэ.

10.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

10.2.1.өөрийн үйл ажиллагааны онцлог, зан үйл, дадлаас хамааран гэмт хэрэг, зөрчилд өртөх, түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй хүн, хуулийн этгээдийн хүрээг тодорхойлох;

10.2.2.энэ хуулийн 10.2.1-д заасан этгээдийн үйл ажиллагаа, зан үйл, дадал гэмт хэрэг, зөрчлийг өдөөж болзошгүй шалтгаан, нөхцөлийг тогтоож, тэдгээрийг саармагжуулах, арилгах арга хэмжээг авах;

10.2.3.гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зан үйл, дадлын талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;

10.2.4.энэ хуулийн 10.2.1-д заасан этгээдэд гэмт хэрэг, зөрчилд өртөх тэдгээрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөх эрсдэлийн талаар таниулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдэгдэл, зөвлөмж өгөх;

10.2.5.энэ хуулийн 10.2.1-д заасан этгээдэд өөрийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх;

10.2.6.гэмт хэрэг, зөрчил үйлдэх, үйлдэгдэхээс өөрийгөө болон бусдыг хамгаалах зан суртахуун, дадал, чадварыг бий болгоход чиглэсэн арга хэмжээг авах;

10.2.7.гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн хор аюулыг олон нийтэд таниулах ажлыг тасралтгүй явуулах, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх.

11 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх

11.1.Гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хянан шалгах ажиллагааг боловсронгуй болгох, түүний үр нөлөөг дээшлүүлэх, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааны бодлогын нэгдмэл байдлыг хангах, хариуцлага хүлээлгэхдээ энэ хуульд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчмыг баримтална.

11.2.Гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.2.1.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх нэгдсэн болон тухайлсан

бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

11.2.2.гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх;

11.2.3.гэмт хэрэг, зөрчлийг хянан шалгах болон түүнд хяналт тавих үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, гэмт хэрэг, зөрчил бүрд хариуцлага хүлээлгэх зарчмыг хэрэгжүүлэх;

11.2.4.гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хохирол, хор уршгийг нөхөн төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

11.2.5.гэмт хэрэг, зөрчил хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага, нэгж, тэдгээрийн алба хаагчдаас чиг үүргээ хэрэгжүүлэх баталгаа, нөхцөлийг сайжруулах;

11.2.6.гэмт хэрэг, зөрчлийн төрлөөс хамааран түүнийг хянан шалгах чиг үүрэг бүхий мэргэшсэн нэгж, алба хаагчдыг бэлтгэх, үйл ажиллагааны чиглэлээр нь мэргэшүүлэх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ЗОХИЦУУЛАЛТ

12 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хамрах хүрээ

12.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил дараах хүн, хуулийн этгээд, харилцаанд хамаарна:

12.1.1. гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдэл, санааг төрүүлж, эсхүл өдөөж байгаа хүчин зүйлс, тэдгээрийг бий болгож байгаа үйл ажиллагаа;

12.1.2. Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол;

12.1.3. үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу зохицуулагдаж, хяналтад байхаар тогтоосон хүн, хуулийн этгээд;

12.1.4. хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тодорхой үүрэг хүлээлгэсэн, хориглолт, хязгаарлалт тогтоосон хүн, хуулийн этгээд;

12.1.5. зан үйл, үйл ажиллагаа нь нийгмийн дэг журам, хэм хэмжээг зөрчиж байгаа, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй гэх үндэслэл бүхий хүн, хуулийн этгээд;

12.1.6. өөрийн үйл ажиллагааны онцлог, зан үйл, дадлаас хамааран гэмт хэрэг, зөрчилд өртөх, түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй хүн, хуулийн этгээд.

13 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч

13.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дараах этгээд хэрэгжүүлнэ:

13.1.1. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл, Салбар зөвлөл, Дэд зөвлөл, тэдгээрийн ажлын алба, түүний дарга, гишүүд;

13.1.2. хууль тогтоомжид заасны дагуу гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хянан шийдвэрлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага, тэдгээрийн харьяа байгууллага, нэгж, тэдгээрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

13.1.3. хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд өөрийн санаачилгаар, төрийн болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байгаа, эсхүл тухайн ажилд оролцож байгаа хуулийн этгээд, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий иргэдийн зөвлөл;

[/Энэ заалт ад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

13.1.4. хууль тогтоомжид заасны дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцож байгаа хувь хүн.

14 дүгээр зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах

14.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр, аймаг, сум, нийслэл, дүүрэгт түүний иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар удирдуулсан орон тооны бус зөвлөл зохицуулна.

[/Энэ хэсэг т 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

14.2. Улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /цаашид “Зохицуулах зөвлөл” гэх/ ажиллах ба орон тооны ажлын албатай байна. Аймаг, нийслэл, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /цаашид “Салбар зөвлөл” гэх/ нь орон тооны нарийн бичгийн даргатай байх бөгөөд орон тооны ажлын албатай байж болно. Зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ажлын албаны дарга байна.

[/Энэ хэсэг т 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

14.3.Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар, Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Зохицуулах зөвлөлөөс баталсан нийтлэг журамд нийцүүлэн батална.

14.4.Зохицуулах зөвлөлийн орон тооны ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан нь төрийн албан хаагч байх бөгөөд албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

[/Энэ хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

15 дугаар зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах

15.1. Зохицуулах зөвлөл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд дараах хэлбэрээр уялдуулан зохицуулна:

15.1.1. гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, тэргүүлэх чиглэл, түүнийг хэрэгжүүлэх үндсэн арга замыг тодорхойлох;

15.1.2. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бодлогын нэгдмэл байдлыг хангах;

15.1.3. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулах, хадгалах, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах арга хэмжээг авах;

15.1.4. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, түүний хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;

15.1.5. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч этгээдээс гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар статистик мэдээг шуурхай харилцан солилцох, хамтран дүн шинжилгээ хийх ажлыг зохицуулах;

15.1.6. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

15.1.7. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар гадаадын болон дотоодын дэвшилтэт техник, технологи, сайн туршлагыг судалж, түүнийг бусад байгууллага, орон нутагт нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

15.1.8. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа арга хэмжээний үр нөлөөг тогтмол судлах, үнэлэх;

15.1.9. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон хуулийн этгээдийг өмчийн хэлбэр харгалзахгүй татан оролцуулах;

15.1.10. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглагддаг техник, технологи, арга ажиллагааны стандартыг боловсруулах, эрх бүхий байгууллагад хүргүүлж баталгаажуулах;

15.1.11. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх.

15.2. Зохицуулах болон Салбар зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд хурлын шийдвэр нь тогтоол, зөвлөмж, мэдэгдэл хэлбэртэй байна.

15.3. Улсын хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дагнан зохицуулах үүрэг бүхий зөвлөлийг /цаашид "Дэд зөвлөл" гэх/ Зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллуулж болно.

15.4. Дэд зөвлөл тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг энэ хуулийн 15.1-д заасан хүрээнд тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулна.

15.5. Салбар болон Дэд зөвлөл түүнчлэн энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан этгээд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тайланг Зохицуулах зөвлөлд жил бүр ирүүлнэ. Зохицуулах зөвлөл улсын хэмжээнд гэмт хэргийн нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашдын төлөв байдлын талаар нэгдсэн тайланг жил бүр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, хоёр жил тутамд Улсын Их Хуралд танилцуулна.

16 дугаар зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сум, нийслэл, дүүргийн хэмжээнд уялдуулан зохицуулах

[/Энэ зүйлийн гарчиг т 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

16.1. Салбар зөвлөл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сум, нийслэл, дүүргийн хэмжээнд дараах хэлбэрээр уялдуулан зохицуулна:

[/Энэ хэсэг т 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

16.1.1. хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;

16.1.2. энэ хуулийн 15.1.1-д заасантай нийцүүлэн хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх;

16.1.3. тухайн нутаг дэвсгэрийн төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага, олон нийтийн оролцоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хангах;

16.1.4.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар нутаг дэвсгэр хариуцсан хууль сахиулах болон бусад байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, түүний хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;

16.1.5.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах, дээд шатны байгууллагад танилцуулах;

16.1.6.энэ хуулийн 15.1.9, 15.1.10, 15.1.11-д заасан болон хуульд заасан бусад хэлбэрээр.

17 дугаар зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөлийн бүрэн эрх

17.1. Зохицуулах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1. Дэд зөвлөл байгуулах, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

17.1.2. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар улсын хэмжээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, түүний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах;

17.1.3. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

17.1.4. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн төслийг боловсруулахад оролцох;

17.1.5. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээний талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

17.1.6. өөрийн эрх хэмжээний хүрээнд төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагатай харилцах, хамтран ажиллах;

17.1.7. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны үр дүнтэй байдлыг хангах, төрийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

17.1.8. холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, эрдэмтдийн төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

17.1.9. Салбар болон Дэд зөвлөл, төрийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажил, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, шалгалт хийх;

17.1.10. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах, түүнийг хэрэгжүүлэх талаар Салбар болон Дэд зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

17.1.11. төрийн захиргааны төв болон бусад байгууллага, Салбар болон Дэд зөвлөлөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан ажлын тайланг гаргуулан авах;

17.1.12. гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомж, Зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлтийг төрийн захиргааны төв болон бусад байгууллагад өмчийн харьяалал харгалзахгүйгээр шалгах, түүний удирдах ажилтны илтгэл, сонголтыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж чиглэл өгөх;

17.1.13. нийтийн хэв журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хуваарилах, зарцуулах;

17.1.14. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайланг холбогдох байгууллагаас хагас, бүтэн жилээр гаргуулан авч, дүгнэлт хийх;

17.1.15. шаардлагатай гэж үзвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн зарим хэсгийг Зохицуулах зөвлөлийн мэдэлд төвлөрүүлж, тодорхой цогц арга хэмжээнд зарцуулах;

17.1.16. Зохицуулах зөвлөлийн хуралдааны шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх талаар холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах, хариу авах;

17.1.17. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

17.1.18. хууль тогтоомж болон хууль тогтоомжийн төсөлд дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжийн төсөл нь гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй тохиолдолд энэ талаар үндэслэл бүхий санал, зөвлөмжийг хууль санаачлагч болон Улсын Их Хуралд хүргүүлэх;

17.1.19. Салбар зөвлөлийн ажиллах нийтлэг журмыг батлах.

[Энэ заалт ад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.](#)

17.2. Салбар болон Дэд зөвлөл нь өөрийн чиг үүрэгт хамаарах энэ хуулийн 17.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

18 дугаар зүйл. Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах

18.1. Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу тухайн төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан хариуцна.

18.2.Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дараах хэлбэрээр гүйцэтгэнэ:

18.2.1.зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага бүр чиг үүргийн дагуу зөрчлийн статистикийн үйл ажиллагаа эрхлэх, статистик мэдээллийг солилцох;

18.2.2.зөрчлийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох;

18.2.3.зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

18.2.4.төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага, олон нийтийн оролцоотойгоор зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах;

18.2.5.зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа болон зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, хөтлөх;

18.2.6.зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар төрийн бодлого болон Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай саналыг боловсруулах;

18.2.7.зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа арга хэмжээний үр нөлөөг тогтмол судлах, үнэлэх;

18.2.8.зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр харгалзахгүй татан оролцуулах;

18.2.9.зөрчлийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх.

18.3.Улсын ерөнхий прокурорын газар улсын хэмжээнд зөрчлийн статистикийн үйл ажиллагаа эрхэлж, түүний нэгдмэл байдлыг хангана.

18.4.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Улсын ерөнхий прокурорын газартай хамтран зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх төрийн бодлого, Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын бодлогын нэгдмэл байдлыг хангана.

18.5.Энэ хуулийн 18.1-д заасан байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 18.2.4-т заасан хөтөлбөр, төлөвлөгөө, биелэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд жил бүр хүргүүлнэ.

18.6.Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөлийг Засгийн газрын шийдвэрээр хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд байгуулж болно.

19 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх

19.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг улсын хэмжээнд болон Салбар болон Дэд зөвлөл, төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагын түвшинд гурван жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, үйл ажиллагаанд нь дүгнэлт хийнэ.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан байгууллага нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, ашиг сонирхлын зөрчилгүй хуулийн этгээд байх бөгөөд түүнд тавих шаардлага, сонгон шалгаруулах журмыг Зохицуулах зөвлөл батална.

20 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх

20.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг энэ хуульд заасны дагуу баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явуулна.

20.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө нь олон нийтийн хэрэгцээ, шаардлага, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашдын төлөв байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үндэслэсэн байна.

20.3.Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд түүнийг баталсан байгууллага, албан тушаалтан хяналт тавина.

21 дүгээр зүйл. Хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх

21.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтны ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, эсхүл тодорхой чиглэлээр мэргэшүүлэх зорилгоор сургалтад тогтмол хамруулна.

21.2.Энэ хуулийн 21.1-д заасан сургалтыг дээд боловсролын сургалтын болон судалгаа, шинжилгээний байгууллага, эсхүл гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг түшиглэн зохион байгуулах бөгөөд дагнасан сургалтын төвийг нийслэл, түүнчлэн бүсийн төвд байгуулж болно.

21.3.Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сургах, бэлтгэхдээ тодорхой чиглэлээр мэргэшүүлэх, албан тушаалд томилохдоо мэргэшсэн чиглэлийг үндэслэл болгох зарчмыг баримтална.

21.4.Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан тушаалтны ажлын ачааллыг Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд үндэслэн тодорхой хугацааны давтамжтайгаар тогтоож, олон улсын жишигт нийцүүлэх, хүний нөөц, шаардлагатай орон тоог тухай бүр шийдвэрлэнэ.

22 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлийн талаар судалгаа

22.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч байгууллага гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын судалгааг хоёр жил тутам гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг гурван жил тутам улсын хэмжээнд, эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд, эсхүл тодорхой гэмт хэрэг, зөрчлийн төрлөөр олон нийтийн дунд зохион байгуулна.

22.2. Энэ хуулийн 22.1-д заасан судалгаа нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх байгууллага, тэдгээрийн албан ёсны тоо мэдээнээс хараат бус байх бөгөөд гэмт хэрэг, зөрчлийн бодит нөхцөл байдлыг тогтоох, гэмт хэрэг, зөрчлийн нийгэмд үзүүлж байгаа нөлөөлөл, хор уршгийг тогтоох зорилготой байна.

22.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 22.1-д заасан судалгааны үр дүнг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх үндэслэл болгоно.

23 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлийн статистикийн үйл ажиллагаа эрхлэх

23.1. Гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого боловсруулах, иргэнд шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор хууль сахиулах, прокурор, шүүхийн захиргааны байгууллага нь гэмт хэрэг, зөрчлийн цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглана.

23.2. Энэ хуулийн 23.1-д заасан байгууллага нь гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох зорилгоор гэмт хэрэг, зөрчлийн статистикийн үйл ажиллагааг дараах байдлаар эрхэлнэ:

23.2.1. гэмт хэрэг, зөрчлийн талаар тоо бүртгэл хөтлөх, цахим мэдээллийн сан бүрдүүлж ашиглах, мэдээлэл гаргаж өгөх, дамжуулах;

23.2.2. гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг боловсруулах, хадгалах, статистикийн мэдээлэл гаргах, судалгаа, дүн шинжилгээ хийх, хэвлэн нийтлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах.

23.3. Энэ хуулийн 23.2-т заасан албан ёсны статистикийн мэдээллийн маягт, аргачлалыг тухайн байгууллагатай зөвшилцөн Үндэсний статистикийн хороо баталж, захиргааны статистикийн мэдээллийн маягт, аргачлалыг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрснөөр тухайн байгууллага батална.

24 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах эрдэм шинжилгээний ажил

24.1. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах ажлыг эрхлэх эрдэм шинжилгээний байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний харьяанд ажиллаж, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа баримтална.

24.2. Энэ хуулийн 24.1-д заасан эрдэм шинжилгээний байгууллага нь гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах шинжилгээ судалгааны ажлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний болон сонирхогч бусад хүн, хуулийн этгээдийн захиалгаар гүйцэтгэж, санхүүжнэ.

24.3. Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.3.1. гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг хэрэгжүүлэгч болон нутгийн захиргааны байгууллага, нийгмийн тодорхой бүлгийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдээллээр хангах;

24.3.2. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг, арга хэрэгслийг ашиглах, хөгжүүлэх, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

24.3.3. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл, арга хэрэгслийг системчлэх, тэдгээрийн хийдэл, дутагдлыг арилгах;

24.3.4. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл, арга хэрэгслийг олон нийт болон шинжлэх ухааны бусад салбар, байгууллага, ажилтантай солилцох;

24.3.5. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, санал, санаачилга гаргах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гарч болзошгүй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал боловсруулах;

24.3.6. хууль тогтоомж болон хууль тогтоомжийн төсөлд дүн шинжилгээ хийх;

24.3.7. энэ хуулийн 22.1-д заасан судалгааг явуулах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

25 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар Засгийн газрын бүрэн эрх

25.1. Засгийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 25.1.1.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого, чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх;
- 25.1.2.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой харилцааг зохицуулсан хэм хэмжээний акт батлах;
- 25.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны үр нөлөөг сайжруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн төсөл боловсруулах;
- 25.1.4.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.4-т заасан чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг батлах;
- 25.1.5.энэ хуулийн 25.1.4-т заасан хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж, Улсын Их Хуралд танилцуулах;
- 25.1.6.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журмыг батлах;
- 25.1.7.хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Зохицуулах зөвлөлийн журам, бүрэлдэхүүнийг батлах;

[/Энэ заал т ад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 25.1.8.төрийн захиргааны төв болон Засгийн газрын агентлагийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хяналт тавих;
- 25.1.9.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэргэшсэн нэгж, мэргэжилтэн бэлтгэх.
- 25.1.10.энэ хуулийн 8.2.10-т заасан зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам батлах.

[/Энэ заал т-ыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

25.2.Засгийн газар нутгийн захиргааны байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

26 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

26.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 26.1.1.төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон шүүх, прокурор, хууль сахиулах бусад байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлыг уялдуулан зохицуулах, Зохицуулах зөвлөлийг удирдах;
- 26.1.2.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих, шалгах;
- 26.1.3.шүүх, прокурор, цагдаа болон хууль сахиулах бусад байгууллагатай зөвшилцөн улсын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;
- 26.1.4.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах;
- 26.1.5.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 26.1.6.гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах.

27 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын үүрэг

27.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бүх шатны төрийн байгууллага энэ хуулийн 30.1-д зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ:

- 27.1.1.хариуцсан чиг үүрэг, эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, иргэдэд хуулийг сахин биелүүлэх дадал бий болгоход чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 27.1.2.хуульд заасан эрх хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бусад байгууллагад дэмжлэг үзүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах;
- 27.1.3.эрхлэх асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах;
- 27.1.4.эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгах тухай мэдэгдэл хүргүүлэх, биелэлтэд хяналт тавих;
- 27.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

28 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар нутгийн захиргааны байгууллагын үүрэг

28.1.Нутгийн захиргааны бүх шатны байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

- 28.1.1.нутгийн захиргааны бүх шатны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах;
- 28.1.2.харьяа нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулах;
- 28.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх;
- 28.1.4.шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжин туслах;
- 28.1.5.харьяа нутаг дэвсгэрийн иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлын талаар мэдээлэл өгөх;
- 28.1.6.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, боловсронгуй болгох;
- 28.1.7.нутаг дэвсгэртээ бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүгнэлт хийж, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаач, шинжээчтэй хамтран ажиллах;
- 28.1.8.ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай ажилласан хуулийн этгээд, иргэний үйл ажиллагааг дэмжих;
- 28.1.9.нутаг дэвсгэр хариуцсан хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөнд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 28.1.10.хууль тогтоомжид заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахдаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого баримтлах;
- 28.1.11.харьяа нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газар, интернэт кафе болон барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчид тавих шаардлага, ажиллах цагийн хуваарийг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлэх;

[/Энэ заал т ад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

- 28.1.12.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх болон мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодисыг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаанд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих;
- 28.1.13.гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх дадал, туршлага олоход нь дэмжлэг үзүүлэх;
- 28.1.14.нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн байцаагч томилон ажиллуулах;
- 28.1.15.иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулан ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын аюулгүй байдал, хэвийн ажиллах нөхцөл, боломжийг байнгын бүрдүүлж, арчлан хамгаалах, шаардагдах зардлыг хариуцах;

[/Энэ заал т ыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

28.1.16.хууль тогтоомжид заасан бусад.

[/Энэ заал т ын дугаарт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

29 дүгээр зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн хяналт шалгалтын байгууллагын үүрэг

29.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн хяналт шалгалтын байгууллага дараах үүрэг хүлээнэ:

- 29.1.1.гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, түүнийг арилгах;
- 29.1.2.гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй этгээдийг тогтоох, урьдчилан сэргийлэх бүртгэлд хамруулах;
- 29.1.3.гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж байгаа этгээдийг олж илрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох;
- 29.1.4.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоог хангах, хамтран ажиллах;
- 29.1.5.гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын тэргүүлэх чиглэлийг тогтоох;
- 29.1.6.гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө гаргах, харьяа нэгж, байгууллага, алба хаагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- 29.1.7.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, сайжруулах талаар санал боловсруулах;

- 29.1.8.хариуцсан нутаг дэвсгэр, чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ тогтмол хийх;
- 29.1.9.харьяа нэгж, байгууллага, алба хаагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт тогтмол өгч, үйл ажиллагааг нь сайжруулах арга хэмжээг авах;
- 29.1.10.нутгийн захиргааны байгууллага, хариуцсан нутаг дэвсгэр, чиг үүрэгт хамаарах хуулийн этгээд, түүний албан тушаалтанд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл болон түүнийг арилгах тодорхой арга хэмжээний талаар мэдэгдэл, зөвлөмж хүргүүлэх;
- 29.1.11.хууль тогтоомжид заасны дагуу ял шийтгүүлсэн этгээдэд хяналт тавих;
- 29.1.12.хууль тогтоомжид заасан бусад.

30 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн этгээдийн нийтлэг үүрэг

30.1.Хуулийн этгээд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

- 30.1.1.байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, арилгах талаар тодорхой арга хэмжээг авах;
- 30.1.2.үйл ажиллагаа явуулж байгаа байршил, түүний ойр орчимд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг авах;
- 30.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг ажилтнууддаа мэдээлэх, сурталчлах;
- 30.1.4.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 30.1.5.барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа стандартад нийцсэн дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хэвийн ажиллагаанд байнгын хяналт тавих;

[Энэ заалт ад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан./](#)

30.1.6.хууль тогтоомжид заасан бусад.

30.2.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх талаар энэ хуулийн 13.1.4-т зааснаас бусад этгээдийн мэдэгдэл, зөвлөмж, шаардлагыг хүлээн авсан хуулийн этгээд түүний дагуу тодорхой арга хэмжээг авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй.

30.3.Энэ хуулийн 30.1.5-д заасан дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.

30.4.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, урьд өмнө гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тэдэнд зориулсан ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх дадал, туршлага олоход нь дэмжлэг үзүүлж болно.

31 дүгээр зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар иргэний эрх, үүрэг

31.1.Иргэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

- 31.1.1.бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах, гэмт хэрэг, зөрчилд бусдыг өдөөн хатгахгүй, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг гажуудуулах үйлдэл гаргахгүй байх;
- 31.1.2.оршин суугаа нутаг дэвсгэртээ нийтийн хэв журам сахиулах талаар нутгийн захиргааны байгууллага, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах байгууллагаас хэрэгжүүлж байгаа зохион байгуулалттай арга хэмжээг дэмжиж, сайн дураар оролцох;
- 31.1.3.гэмт хэрэг, зөрчлийн талаар олж мэдсэн зүйлээ холбогдох байгууллагад мэдээлэх;
- 31.1.4.гэмт халдлагаас өөрийн буюу бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хуулийн хүрээнд хамгаалах;
- 31.1.5.гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох талаар бусдаас шаардах, шуурхай мэдээлэх, нуун дарагдуулахгүй байх, цагдаа, хуулийн байгууллагатай хуулийн хүрээнд хамтран ажиллаж, туслалцаа үзүүлэх;
- 31.1.6.хууль бусаар галт зэвсэг, хутга, зэвсгийн чанартай зүйл, тусгай хэрэгсэл олж авах, хадгалах, худалдах, биедээ авч явахгүй байх;
- 31.1.7.улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу холбогдох бүртгэлийг хийлгэж, баримт бичгийг эзэмших талаарх журмыг чанд сахих;
- 31.1.8.үр хүүхэд, өөрийн асрамжид байгаа насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулахгүй байх;
- 31.1.9.хууль тогтоомжид заасан бусад.

31.2.Иргэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах эрх эдэлнэ:

- 31.2.1. олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам сахихыг бусдаас шаардах;
- 31.2.2. гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах тухай асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавих, шаардах;
- 31.2.3. гэмт халдлагаас эд хөрөнгө, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хуулийн хүрээнд хамгаалах;
- 31.2.4. хуульд заасан үүргээ биелүүлсний төлөө учирч болох эрсдэлээс хамгаалуулах;
- 31.2.5. хууль тогтоомжид заасан бусад.

32 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг

- 32.1. Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээ, сурвалжлага хийх, нэвтрүүлэг бэлтгэхдээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг олон нийтэд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгоно.
- 32.2. Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлнэ.
- 32.3. Энэ хуулийн 32.2-т заасан хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
- 32.4. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль ёсны аргаар хамгаалах арга замыг тодорхой тусгаж хэрэгжүүлнэ.
- 32.5. Энэ хуулийн 32.4-т заасан агуулга бүхий нийтлэл, мэдээллийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, нийтэлж байгаа нийт мэдээлэлд эзлэх хувь, заавал нэвтрүүлбэл зохих нийтлэл, мэдээллийн доод хэмжээг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
- 32.6. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, түүний ул мөрийг нуун далдлах арга, хэрэгслийг нарийвчлан дүрсэлсэн, гэмт хэрэг, зөрчлийг ашиг, орлогоо нэмэгдүүлэх хэрэгсэл болгон харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдэл төрүүлж болох агуулгатай аливаа мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхийг хориглоно.
- 32.7. Шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай болон гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.
- 32.8. Хэвлэл, мэдээллийн байгууллага гэмт хэргийн шинжтэй, илт хууль бус нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгааны тухай асуудлыг цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй.
- 32.9. Гэрч, хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүний нүүр царай, дуу хоолойг танигдахуйц байдлаар гаргах, хувийн байдалтай холбоотой мэдээллийг тараах, хохирогчийг буруутгасан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хийхийг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ХЭЛБЭР

33 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах

- 33.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа иргэдийг дараах хэлбэрээр татан оролцуулна:
 - 33.1.1. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах;
 - 33.1.2. гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах;
 - 33.1.3. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн санал, санаачилгыг дэмжих;
 - 33.1.4. төрийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгох;
 - 33.1.5. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах;
 - 33.1.6. иргэдээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцох баталгааг хангах;
 - 33.1.7. нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн байцаагчийн үүрэг гүйцэтгүүлэх.

34 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах

- 34.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна.

34.2.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэний өгсөн мэдээллийн дагуу зөрчилд 200 хүртэл нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол иргэнд тухайн шийтгэлийн 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний, 200-аас дээш нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

34.3.Энэ хуулийн 34.1, 34.2-т заасны дагуу урамшуулах хэлбэр, журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

34.4.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэл гаргасан, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсооход онцгой үүрэг гүйцэтгэсэн хүнийг урамшуулах, төрийн болон Засгийн газрын шагналд тодорхойлох шийдвэрийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын саналыг харгалзан Зохицуулах болон Салбар, Дэд зөвлөлийн дарга гаргана.

35 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах

35.1. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг гэмт хэрэг, зөрчлийг хянан шалгах эрх бүхий байгууллага иргэдээс төлбөртэй авч болно.

35.2. Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг төлбөртэй авах ажиллагаанд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.5 дугаар зүйлийг баримтална.

35.3. Гэмт хэрэг, зөрчлийн хэрэг бүртгэл, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтан мэдээллийн нууцыг чанд хадгалж, шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах үүрэгтэй.

36 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн санал, санаачилгыг дэмжих

36.1. Энэ хуулийн 14.1-д заасан хууль сахиулах болон төрийн захиргааны байгууллага нь иргэд, хуулийн этгээд, төрийн бус байгууллагаас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх шинэ арга барил, ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн талаар санал, санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.

36.2. Энэ хуулийн 36.1-д заасныг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

36.2.1. хүний эрхийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, судлаачийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа ажилд оролцуулах;

36.2.2. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг санхүүжүүлэх, тухайн үйл ажиллагааг мэдээ, мэдээллээр хангах замаар дэмжлэг үзүүлэх;

36.2.3. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар шинэ техник, технологи зохион бүтээх, үйл ажиллагаанд ашиглахад дэмжлэг үзүүлэх;

36.2.4. хүүхэд, залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил эрхэлдэг хуулийн этгээдэд санхүүгийн болон бусад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

36.2.5. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн санаачилгыг дэмжиж, шаардлагатай бол хэрэгжүүлэх арга хэмжээг авах.

37 дугаар зүйл. Төрийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгох

37.1. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа олон нийтийн хяналт доор явагдах бөгөөд нээлттэй, ил тод байна.

37.2. Энэ хуулийн 37.1-д заасан олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч нь төрийн хяналт шалгалт хийх эрхгүй байх бөгөөд хяналтыг хэрэгжүүлэхдээ байгууллага, албан тушаалтны эрх хэмжээний асуудлаар шийдвэр гаргах болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

37.3. Энэ хуулийн 37.1-д заасан олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батална.

38 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах

38.1. Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангана.

38.2. Энэ хуулийн 38.1-д заасан олон нийтийн оролцоог хангах ажиллагаа дараах байдлаар хэрэгжинэ:

38.2.1. Зохицуулах болон Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаанд иргэдийн төлөөллийг оролцуулах;

38.2.2. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд иргэдийн төлөөллийг оролцуулах;

38.2.3. хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тухайн төслийн талаар олон нийтийн саналыг авах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах;

38.2.4. хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад иргэдээс гаргасан саналыг судлан үзэж, шаардлагатай өөрчлөлтийг хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах;

38.2.5.хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлын талаар олон нийтийн дунд санал асуулга зохион байгуулах, хөтөлбөр, төлөвлөгөөг олон нийтийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх;

38.2.6.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төсвийн зарцуулалтад олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох.

39 дүгээр зүйл.Иргэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцох баталгааг хангах

39.1.Иргэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан эрхээ хэрэгжүүлэх явцад бусдад учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцахгүй бөгөөд хохирлыг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

39.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлсэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцсонтой нь холбогдуулан хүн, хуулийн этгээдэд хохирол учирсан нь тогтоогдсон бол хохирлыг энэ хуулийн 46.1-д заасан хөрөнгөөс санхүүжүүлж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

39.3.Иргэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваад эрүүл мэндээрээ хохирсон, эсхүл амь насаа алдсан тохиолдолд түүнд болон ар гэрт нь дараах тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү болон зардлыг олгоно:

39.3.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, авч байсан цалингийн зөрүү;

39.3.2.тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр болон авч байсан цалингийн зөрүү;

39.3.3.амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, авч байсан цалингийн зөрүү;

39.3.4.хиймэл эрхтэн хийлгэх бол түүний зардал.

39.4.Энэ хуулийн 39.3.2, 39.3.3-т заасан тэтгэвэр тогтоосноос хойш хохирогчийн тухайн үед авч байсан цалинд өөрчлөлт орсон бол зөрүүг шинээр тогтоосон хэмжээнээс тооцож олгоно.

39.5.Энэ хуулийн 39.3.2, 39.3.3-т заасан тэтгэвэр, цалингийн зөрүүг тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа хугацаанд олгоно.

39.6.Энэ хуулийн 39.3-т заасан хүн нь тогтмол цалин, орлогогүй, эсхүл тодорхой ажил эрхлээгүйгээс тэтгэвэр, тэтгэмж авч чадахгүй бол түүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээгээр нөхөн төлбөр олгоно.

39.7.Нөхөн төлбөрийг тухайн хүнийг хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанд олгоно.

39.8.Энэ хуулийн 39.3, 39.6-д заасан тэтгэвэр, тэтгэмж, цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэх зардал, нөхөн төлбөрийг гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх зардлаас олгож, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

39.9.Энэ зүйлд заасан иргэний гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээрх үйл ажиллагаатай холбоотойгоор хохирсон хуулийн этгээдийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд нэгэн адил хамаарна.

40 дүгээр зүйл.Нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн байцаагчийг томилох

40.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн бус байгууллага болон баг, хорооны Засаг даргын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэх олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулна.

40.2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүн амын нягтрал, гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшинг харгалзан харьяа нутаг дэвсгэртээ ажиллах олон нийтийн байцаагчийн тоог тогтооно.

40.3.Цагдаагийн байгууллага олон нийтийн байцаагчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах бөгөөд иргэд, хуулийн этгээд, олон нийтийн байцаагчид энэ хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх үүрэгтэй.

40.4.Олон нийтийн байцаагчид энэ хуулийн 34.3-т заасан журмын дагуу урамшуулал олгоно.

40.5.Олон нийтийн байцаагч нийтийн хэв журмыг сахиулах талаар дараах эрх, үүрэг хүлээнэ:

40.5.1.хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулах;

40.5.2.нийтийн хэв журам сахиулах талаар нутгийн захиргааны болон цагдаа, төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа ажилд оролцох, туслалцаа үзүүлэх;

40.5.3.хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл зохион байгуулж, илэрсэн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох арга хэмжээг авах, холбогдох байгууллагад мэдэгдэх;

40.5.4.гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, хууль бус үйлдлээ зогсоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг арилгуулах тухай шаардлага тавих, баримт бичиг шалгах;

40.5.5.гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгуулах.

40.6.Олон нийтийн байцаагч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрхээ хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан баталгаагаар хангагдана.

40.7.Олон нийтийн байцаагчийн ажиллах нийтлэг журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХОРИХ ЯЛ ЭДЛЭЭД СУЛЛАГДСАН ХҮНД ХЯНАЛТ ТОГТООХ

41 дүгээр зүйл.Хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тогтоох

41.1.Эрүүгийн хуулийн 10.1, 11.2, 12.1, 12.3, 15.1, 15.5, 15.6, 16.2, 17.1, 18.6, 19.2, 19.5, 19.6, 19.8, 20.3, 20.7, 20.8, 26.1, 26.2, 26.3, 29.8, 29.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж суллагдсан болон хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж, Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14 дүгээр зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хяналтын хугацаа нь дууссан хүнд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт тогтооно.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасан хяналтыг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, түүний алба хаагч гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд цагдаагийн төв байгууллагын шийдвэрээр үйлдсэн гэмт хэргийн төрлөөс хамааран тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг дагнан хэрэгжүүлж байгаа цагдаагийн байгууллагын нэгж, алба хаагчид даалгаж болно.

41.3.Хяналтад байгаа хүний хяналтын хугацаа дууссан бол уг хяналтыг тавьж байгаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хяналтыг дуусгавар болгоно.

41.4.Энэ хуулийн 41.1-д заасан хүн хорих ял эдлэн суллагдаж, эсхүл чөлөөлөгдөж байнга оршин суух газартаа очсоноос хойш долоо хоногийн дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

41.5.Хорих байгууллага хорих ял эдэлж байгаа хүнийг суллагдахаас 30 хоногийн өмнө, хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.6 дугаар зүйлд заасан хяналтын хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө, Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14 дүгээр зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн даруй тус тус байнга оршин суух газрын цагдаагийн байгууллагад түүний суллагдах тухай мэдэгдлийг зохих тодорхойлолтын хамт хүргүүлнэ.

42 дугаар зүйл.Хяналт тавих хугацаа

42.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хяналтыг энэ хуулийн 41.1-д заасан хүнд оногдуулсан хорих ялын хугацаатай уялдуулан нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр нэгээс гурван жил хүртэл хугацаагаар тогтооно.

42.2.Хяналтад байгаа хүн урьд өмнө хяналтад байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн бол хяналтын хугацаа нь энэ хуулийн 42.1-д заасан хугацаан дээр хоёр жилийн хугацааг нэмж тогтооно.

42.3.Хяналтад байгаа хүн хяналтаас зайлсхийсэн /хуульд заасны дагуу бүртгүүлээгүй, эсхүл бүртгүүлсэн боловч гурван сар, түүнээс дээш хугацаагаар цагдаагийн байгууллагад бүртгүүлээгүй/, оргон зайлсан /хуульд заасны дагуу бүртгүүлээгүй, эсхүл бүртгүүлсэн боловч зургаан сар, түүнээс дээш хугацаагаар цагдаагийн байгууллагад бүртгүүлээгүй/, эсхүл энэ хуулийн 43.1-д заасан үүргээ удаа дараа /3 ба түүнээс дээш удаа/ биелүүлээгүй бол энэ хуулийн 42.1-д заасан албан тушаалтны шийдвэрээр хяналтын хугацааг тухай бүр зургаан сарын хугацаагаар сунгаж тогтооно.

42.4.Хяналтад байгаа хүн гэмт хэрэг дахин үйлдэж болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдэн эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдан шалгагдаж байгаа тохиолдолд энэ хуулийн 42.1-д заасан албан тушаалтны шийдвэрээр тухайн үндэслэл арилах хүртэл хугацаагаар хяналтын хугацааг сунгаж болно.

42.5.Хяналтад байгаа хүн хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа бөгөөд ажил хөдөлмөр эрхлэлт, зан төлөвийн хувьд засарч нийгэмд бүрэн дасан зохицсон, цаашид гэмт хэрэг үйлдэхгүй гэх хангалттай үндэслэл тогтоогдсон, эсхүл гадаад улсад удаан хугацаагаар зорчих бол энэ хуулийн 42.1-д заасан албан тушаалтны шийдвэрээр хугацаанаас өмнө хяналтыг дуусгавар болгож болно.

42.6.Энэ хуулийн 42.2, 42.3, 42.4-т заасны дагуу хяналтын хугацааг сунгасан бол хяналт тавих нийт хугацаа нь тухайн хүний үйлдсэн гэмт хэрэгт оногдуулахаар Эрүүгийн хуульд заасан хорих ялын дээд хугацаанаас хэтэрч болохгүй.

42.7.Хяналтын хувийн хэргийн загвар, хугацааг тогтоох жишгийг цагдаагийн төв байгууллагын дарга Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн тогтооно.

43 дугаар зүйл.Хяналтад байгаа хүний үүрэг

43.1.Хяналтад байгаа хүн дараах үүрэг хүлээнэ:

43.1.1.хууль тогтоомжийг дээдлэн хүндэлж, сахин биелүүлэх;

43.1.2.сард нэг удаа цагдаагийн байгууллагад биечлэн ирж, бүртгүүлэх;

43.1.3.цагдаагийн байгууллагаас дуудсан цагт ирэх;

43.1.4.байнга оршин суугаа газраа өөрчлөх тохиолдолд хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж, шилжин очсон нутаг дэвсгэрийг хариуцсан цагдаагийн байгууллагад долоо хоногийн дотор бүртгүүлэх;

43.1.5.байнга оршин суугаа газраасаа 14 хоногоос илүү хугацаагаар явах, гадаад улсад зорчих бол цагдаагийн байгууллагад

урьдчилан мэдэгдэх;

43.1.6.хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллага, алба хаагчийн хууль ёсны шаардлага, эрх бүхий этгээдээс хүлээлгэсэн үүргийг биелүүлэх;

43.1.7.шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээдээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хориглолт, хязгаарлалттай холбоотой асуудлаар амаар болон бичгээр тайлбар гаргах;

43.1.8.хяналт тавьж байгаа албан тушаалтныг хуульд заасны дагуу өөрийн эзэмшил газар, орон байр, эд зүйлд саадгүй нэвтрүүлэх, үзлэг, нэгжлэг хийлгэх.

43.2.Хяналт нь энэ зүйлд зааснаас өөрөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл болохгүй.

44 дүгээр зүйл.Хяналт тавих талаар цагдаагийн байгууллага, алба хаагчийн бүрэн эрх

44.1.Цагдаагийн байгууллага, алба хаагч хяналт тавихдаа дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

44.1.1.хяналтад байгаа хүний зан байдал, үйл ажиллагааны талаар ажиллаж байгаа болон оршин суугаа газрын нутгийн захиргааны байгууллагаас тодорхойлолт, лавлагаа, тайлбар гаргуулж авах;

44.1.2.хяналтад байгаа хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр шаардлагатай тохиолдолд хэдийд ч дуудан ирүүлэх, зөвлөгөө өгөх, шаардлага тавих, анхааруулах;

44.1.3.хяналтад байгаа хүн эрх бүхий этгээдээс тогтоосон хязгаарлалт, үүргийг биелүүлээгүй, эсхүл хяналтаас зайлсхийсэн тохиолдолд түүнийг эрэн сурвалжлах, албадан ирүүлэх;

44.1.4.цаашид гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх талаар хяналтад байгаа хүнд санамж, зөвлөгөө өгөх, ярилцлага зохион байгуулах;

44.1.5.хяналтад байгаа хүн гэмт хэрэг, зөрчил дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хараа хяналтдаа байлгах, сурган хүмүүжүүлэх, удирдах чиг үүрэг бүхий хүнд тодорхой үүрэг хүлээлгэх, биелэлтийг хангуулах;

44.1.6.хяналтад байгаа хүнийг нийгэмд дасан зохицох, ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хүргэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгах, бусад асуудлыг шийдвэрлэх талаар нутгийн захиргааны болон бусад төрийн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.

45 дугаар зүйл.Хяналтын хэлбэр

45.1.Хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, хяналтын хүрээ, хяналтад ашиглах арга хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хяналтад байгаа хүний үйлдсэн гэмт хэргийн төрөл, онцлог, түүний хувийн байдалд нийцүүлэн ялгамжтайгаар тогтооно.

45.2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээ дараах хэлбэртэй байна:

45.2.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ярилцлага хийх, зөвлөгөө өгөх;

45.2.2.хяналтад байгаа хүнийг нийгэмд дасан зохицох, ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

45.2.3.ял шийтгүүлсэн гэмт хэргийн төрөл, хувийн байдлаас хамааран урьд өмнө гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хүргэсэн шалтгаан, нөхцөлийг арилгах талаар тодорхой үүрэг өгч, биелэлтийг хангуулах;

45.2.4.хяналтад байгаа хүний зан үйл, хөдөлмөр эрхлэлт, үйл ажиллагааны талаар тусгайлсан шаардлага, хориглолт, хязгаарлалт тогтоох;

45.2.5.ажил хөдөлмөр эрхлэлтийн байдал, үйл ажиллагааг нь биечлэн шалгах;

45.2.6.мансууруулах эм, сэтгэгдэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй холбоотой гэмт хэрэг үйлдэж тэнсэн харгалзсан этгээд мансууруулах эм, бодис хэрэглэсэн эсэхийг тодорхой цаг хугацааны давтамжтайгаар шалгах;

45.2.7.хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авах, захиргааны журмаар албадан эмчилгээнд хамруулах.

45.3.Хяналтад байгаа хүн энэ хуулийн 42.1-д заасны дагуу тогтоосон хугацааны эхний хагаст зан байдлаараа нийтэд аюулгүй болсон гэдгээ нотлон харуулсан бөгөөд цаашид тогтмол хяналт тавих шаардлагагүй бол хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хяналтын үлдсэн хугацаанд энэ хуульд заасан хяналтын түвшинг хөнгөрүүлж болно.

45.4.Энэ хуулийн 45.2-т заасан хяналтад байгаа хүний эерэг зан, төлөв байдлаас хамааран урамшуулах буюу цагдаагийн байгууллага, алба хаагч хяналтад байгаа хүнийг зайлшгүй шаардлага гарснаас бусад тохиолдолд цагдаагийн байгууллагад дуудахгүй байх, энэ хуулийн 43.1.2, 43.1.4, 43.1.5-д заасан хугацаа, давтамжийг хуульд зааснаар сунгаж тогтоох болон урьд тогтоосон зарим үүрэг, хориглолт, хязгаарлалтыг цуцлах байдлаар хэрэгжүүлнэ.

45.5.Хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагыг сайн дурын үндсэн дээр оролцуулж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН

46 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт

46.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.2, 5.3 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.5, 5.6, 5.7 дугаар зүйл, 5.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 5.9 дүгээр зүйл, 5.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 4, 6 дахь хэсэг, 5.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 5.16, 5.18 дугаар зүйл, 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 4, 5, 11, 12, 13 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 4, 7 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 4, 5, 7, 9 дэх хэсэг, 6.21, 6.22 дугаар зүйл, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8.8 дугаар зүйл, 10.4, 10.8, 10.26, 10.28 дугаар зүйл, 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 13.5, 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.18 дугаар зүйл, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.21 дүгээр зүйл, 15.22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

[/Энэ хэсэг т 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

46.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт нь энэ хуулийн 46.1-д зааснаас гадна хуулиар хориглоогүй бусад санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдэнэ.

46.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна.

46.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. Журамд энэ хуулийн 46.1-д заасан дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн систем сайжруулах ажилд зарцуулах 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад төвлөрүүлэн хуваарилж, санхүүжүүлэх асуудлыг тусгана.

[/Энэ хэсэг т 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

46.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна:

46.5.1. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн бус байгууллага, иргэдээс иргэд, байгууллагын дунд зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгааны ажлын зардлыг санхүүжүүлэх;

46.5.2. энэ хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг шагнаж, урамшуулах;

46.5.3. энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваад эрүүл мэндээрээ хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд болон ар гэрт нь олгох тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх;

46.5.4. гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон шүүхийн шинжилгээний байгууллагаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх;

46.5.5. гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг иргэдээс авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх;

46.5.6. гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үнэлгээ, судалгаа хийх, тэдгээрийг хэлэлцүүлэх, хуульд заасан дүрэм, журам, заавар боловсруулах;

46.5.7. тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга, ажиллагааны талаарх судалгааны ажилд зарцуулах;

46.5.8. олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх;

46.5.9. энэ хуулийн 14.2-т заасан Зохицуулах зөвлөлийн орон тооны ажлын албаны үйл ажиллагаа, албан хаагчийн цалин хөлс, Салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын цалин хөлсний зардлыг санхүүжүүлэх;

[/Энэ заал т ыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

46.5.10. хууль тогтоомжид заасан бусад.

[/Энэ заалтыг дугаарт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

46.6.Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгийг зөрчлийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлыг харгалзан асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тухай бүр тусгаж, зарцуулна.

46.7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

46.8.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад Зохицуулах зөвлөл, төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

47 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

47.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

47.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

48 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

48.1.Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР